



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/118

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйл, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/726 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хойд жигүүрийн халаалт болон хэрэглээний халуун усны шугам сүлжээ (Багахангай дүүрэг, 1 дүгээр хороо)-ний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны

дарга: О.Содовжамц

Гишүүд: Д.Хүрэлбаатар

Б.Алтантүлхүүр
Д.Баасанжав

Худалдан авах ажиллагааны албаны
дарга

Засаг даргын Тамгын газрын
Тохижилт, худалдаа үйлчилгээний
хэлтсийн дарга

Илч-Орд ОНӨААТҮГ-ын нярав
1 дүгээр хорооны иргэн

Нарийн бичиг:

Д.Амгалан

Худалдан авах ажиллагааны албаны
Ахлах мэргэжилтэн

2.Хууль, тогтоомжийн дагуу ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Үнэлгээний хороо (О.Содовжамц)-нд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД